



## МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

20 дд оны 1д дугаар  
сарын 09 -ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар  
хот

### Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Газар хөдлөлтийн тухай мэдээ, мэдээллийг дамжуулах, мэдээлэх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Газар хөдлөлтийн тухай мэдээ, мэдээллийг дамжуулах, мэдээлэх журам”-ыг баталсан Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 71 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг иргэдэд шуурхай хүргээмжтэй хүргэх ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал)-д, журмын хэрэгжилтийг ханган, зохион байгуулалтын арга хэмжээ авч, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газар (хошууч генерал Г.Ариунбуян)-т, Газар хөдлөлтийн мэдээллийг богино хугацаанд боловсруулахад тогтмол анхаарч ажиллахыг Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн хүрээлэн (С.Дэмбэрэл)-д тус тус даалгасугай.

Монгол Улсын Шадар сайд



С.АМАРСАЙХАН

. 0022100366

Монгол Улсын Шадар сайдын 2022 оны  
101 дугаар сарын 22 ны өдрийн 22 дугаар  
тушаалын хавсралт

## ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙГ ДАМЖУУЛАХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол орны нутаг дэвсгэр болон хил орчмын бүс нутагт үүссэн газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн харилцаа холбооны сувгаар иргэдэд мэдээлэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Журамд Цахим хөгжил, харилцаа холбооны яам /цаашид “ЦХХХЯ” гэх/, Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн хүрээлэн /цаашид “ООГХ” гэх/, Онцгой байдлын ерөнхий газрын Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв /цаашид “ОБЕГ-ын ШУЗМТ” гэх/, “Жи-Мобайл” ХХК, “Мобиком” ХХК, “Ондо” ХХК, “ОнЛайм сүлжээ” ХХК, “Скайтел” ХХК, “Юнител” ХХК операторыг /цаашид “Үүрэн холбооны оператор” гэх/ гэж тодорхойлно.

### Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. “Мэргэжлийн байгууллага” гэж Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн хүрээлэнгийн Газар хөдлөл судлалын үндэсний мэдээллийн төв;

2.2. “Анхдагч мэдээлэл” гэж Газар хөдлөл судлалын үндэсний мэдээллийн төвийн автомат ажиллагаатай программ хангамжийг ашиглан хүний оролцоогүйгээр тодорхойлсон газар хөдлөлтийн мэдээлэл;

2.3. “Хянасан мэдээлэл” гэж Газар хөдлөл судлалын үндэсний мэдээллийн төвийн ажилтан хянан боловсруулсан газар хөдлөлтийн мэдээлэл;

2.4. “Дэлгэрэнгүй мэдээлэл” гэж тухайн газар хөдлөлтийн газар зүйн байршил, газар хөдлөлт болсон бүсийн ерөнхий мэдээлэл, чичирхийллийг онолын хувьд тооцоолсон зураг зэрэг мэдээлэл;

2.5. “Мэдээлэл хариуцагч байгууллага” гэж ООГХ ба ШУЗМТ;

2.6. “Газар хөдлөлтийн мэдээлэл дамжуулах систем” гэж ООГХ-ээс ОБЕГ-ын ШУЗМТ-д мэдээлэл дамжуулах программ хангамж болон сүлжээ;

2.7. “Мэдээлэх систем” гэж ШУЗМТ-ын “Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх систем”;

2.8. “Үндсэн систем” гэж “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн “ 18.3-т заасан төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем;

2.9. “Дэмжих систем” гэж “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн 18.5.5-т заасан “Мэдэгдэл хүргэх систем”;

2.10. “Мессеж дамжуулах систем” нь үүрэн холбооны оператор компаниудын масс мессеж дамжуулах систем;

2.11. “Цаг хугацаандаа” гэж тухайн бодит цаг хугацаанд мэдээлэл дамжуулах системүүдийн чадвар;

2.12. “Үнэн зөв” байх гэж дамжуулах мэдээ ба дохионы нарийвчлал;

2.13. “Хил орчмын бүс нутаг” гэж Монгол Улсын хилийн зурвасаас гадагш 200 км -ийн хүртэлх бүс нутаг.

Гурав. Газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг  
дамжуулах, мэдээлэх зарчим

3.1. ООГХ-ээс дамжуулах газар хөдлөлтийн мэдээ, мэдээлэл нь огноо, цаг, байршил (аймаг/хот, сум/дүүрэг, уртраг, өргөрөг, зүг чиг, зай), газар хөдлөлтийн хүч (магнитуд)-ний мэдээллийг агуулсан байна.

3.2. ООГХ-ээс газар хөдлөлтийн “Анхдагч мэдээлэл” нь 2 минутын хугацаанд дамжуулагдах бөгөөд энэ нь “Хянасан мэдээлэл”-ээс зөрүүтэй байж болно.

3.3. ООГХ-ээс газар хөдлөлтийн “Хянасан мэдээлэл”-ийг 10 минутын хугацаанд боловсруулж дамжуулах бөгөөд энэ нь үнэн зөв мэдээлэл байна.

3.4. ШУЗМТ нь ООГХ-ээс газар хөдлөлтийн мэдээллийг хүлээн авснаас хойш зарлан мэдээллийг /бүх нийтийн болон хэсэгчилсэн байдлаар/ 2 дугаар хавсралтад заасан хугацаанд багтаан мэдээлнэ.

3.5. ШУЗМТ нь энэ журмын 3 дугаар хавсралтад заасан албан тушаалтнуудад 4.0 магнитуд болон түүнээс дээш хүчтэй газар хөдлөлтийн хянасан мэдээллийг багц мессежээр илгээнэ.

Дөрөв. Газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг дамжуулах,  
мэдээлэхэд тавигдах шаардлага,  
харилцаа холбооны суваг

4.1. Газар хөдлөлтийн мэдээ, мэдээлэл нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд үндэслэгдэх;

4.2. Газар хөдлөлтийн мэдээ, мэдээлэл нь үнэн зөв, товч, тодорхой байх;

4.3. Газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь дараалал харгалзахгүй, үнэ төлбөргүй, хүртээмжтэйгээр иргэд, олон нийтэд хүргэх;

4.4. Газар хөдлөлт болсон бүс нутгийн иргэдэд тухайн газар хөдлөлтийн мэдээллийг нэн тэргүүнд хүргэх;

4.5. “Мэдээлэл хариуцагч байгууллага” нь “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн 18.6, 18.7, 18.9-т заасныг хэрэгжүүлж ажиллах;

4.6. Энэ журмын 2.6, 2.7, 2.8, 2.9, 2.10-т заасан системүүдийн өөрчлөлт, шинэчлэлт нь газар хөдлөлтийн мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх цаг хугацаанд нөлөөлөхгүй байх;

4.7. Энэ журмын 2.6, 2.7-д заасан системүүдийн техникийн бэлэн байдал, ашиглалт үйлчилгээтэй холбоотой зардлыг “Мэдээлэл хариуцагч байгууллага” нь жил бүр улсын төсөвт суулгах;

4.8. Төв, орон нутгийн Онцгой комисс нь өөрийн харьяаллын бүс нутагт суурилагдсан зарлан мэдээлэх системийн тасралтгүй ажиллагааг хангахад шаардагдах зардлыг тухай бүр шийдвэрлэх;

4.9. ООГХ-ээс ШУЗМТ-д газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг дамжуулахдаа дараах харилцаа холбооны сувгийг ашиглана. Үүнд:

- 4.9.1. цахим сүлжээ;
- 4.9.2. цахилгаан холбооны сүлжээ;
- 4.9.3. радио холбооны сүлжээ;

4.10. ШУЗМТ-өөс газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэхдээ дараах харилцаа холбооны сувгийг ашиглана. Үүнд:

- 4.10.1. зарлан мэдээллийн дуут дохиоллын цамхаг;
- 4.10.2. өргөн нэвтрүүлгийн телевиз;
- 4.10.3. өргөн нэвтрүүлгийн радио;
- 4.10.4. мэдэгдэл хүргэх систем;
- 4.10.5. цахилгаан холбооны сүлжээ;
- 4.10.6. цахим сүлжээ;
- 4.10.7. үүрэн холбооны сүлжээ.

Тав. Газар хөдлөлтийн тухай мэдээлэл  
дамжуулах байгууллагуудын үүрэг

5.1. Одон орон геофизикийн хүрээлэн:

5.1.1. ООГХ-ээс монгол орны нутаг дэвсгэр болон хил орчмын бүс нутагт болсон магнитуд нь 3.5 болон түүнээс дээш хүчтэй газар хөдлөлтийн анхдагч, хянасан мэдээллийг цахим шуудан болон “Газар хөдлөлтийн мэдээлэл дамжуулах систем”-ээр энэ журмын 1 дүгээр хавсралтад зааснаар дамжуулна.

5.1.2. газар хөдлөлтийн анхдагч болон хянасан мэдээллийг энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд ШУЗМТ-д дамжуулах, “Газар хөдлөлтийн мэдээлэл дамжуулах систем”-ийн программ хангамжийн бэлэн байдал, хөгжүүлэлт, сайжруулалтыг хариуцах;

5.1.3. газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах;

5.1.4. энэ журмын 2 дугаар хавсралтад заагдсан магнитудаас бага хүчтэй боловч төв, суурин газрын оршин суугчдад мэдрэгдсэн газар хөдлөлт болсон үед тухайн газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг ШУЗМТ-д цахилгаан холбооны утас болон радио станцаар дамжуулна;

5.1.5. газар хөдлөлтийн анхдагч болон хянасан мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд цахим шуудангаар хүргэх;

5.1.6. цахим шуудангийн хаягийг сарын бүрийн 15-ны өдөр тодотгоно.

5.2. Онцгой байдлын ерөнхий газар:

5.2.1. ШУЗМТ нь газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг энэ журмын 2 дугаар хавсралтад зааснаар иргэд, олон нийтэд мэдээлнэ.

5.2.2. ШУЗМТ нь “Газар хөдлөлтийн мэдээлэл дамжуулах систем”-ээс автоматаар “Үндсэн систем”-рүү газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг дараах хэлбэрээр дамжуулна. Үүнд:

5.2.2.1. иргэд, олон нийтэд масс мессежээр хүргэх 160 тэмдэгт бүхий галигласан бичвэр мэдээлэл;

5.2.2.2. иргэд, олон нийтэд хүргэх мэдэгдэл;

5.2.3. ШУЗМТ нь 4.0 ба түүнээс дээш хүчтэй газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг Хавсралт 3-т заагдсан эрх бүхий албан тушаалтанд багц мессежээр хүргэнэ.

5.2.4. ШУЗМТ нь “Мэдээлэх систем”-ийн хэвийн ажиллагааг хангах;

5.2.5. ШУЗМТ нь “Газар хөдлөлтийн мэдээлэл дамжуулах систем”-д гарсан доголдлыг ООГХ-д мэдэгдэх;

5.2.6. ШУЗМТ нь энэ журмын 3 дугаар хавсралтад заасан газар хөдлөлтийн мэдээллийг гар утасны мессежээр хүлээн авах эрх бүхий албан тушаалтны үүрэн холбооны дугаарыг сар бүрийн 15-ны өдөр тодотгох;

5.2.7. ШУЗМТ нь багц мессеж дамжуулах модем, дугаар болон нэгжийн бэлэн байдлыг хангах;

5.2.8. ШУЗМТ нь “Мэдээлэх систем” ажиллах боломжгүй тохиолдолд Хөдөлгөөнт удирдлагын төвөөс мэдээлэх;

5.2.9. ШУЗМТ нь хөдөлгөөнт удирдлагын төвд шилжин ажиллах тохиолдолд Ажиллагааны удирдлагын газрын газар хөдлөлтийн тасаг, Шуурхай удирдлага зарлан мэдээлэх төвийн бэлтгэл ээлжийн алба хаагчид “Улаан” түвшний дохиогоор яаралтай цугларч, бэлэн байдлыг хангуулна.

5.2.10. Олон нийттэй харилцах төв нь газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх болон газар хөдлөлтийн нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр мэдээлэх;

5.2.11. Урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж нь иргэд, олон нийтэд зориулсан зураг, текст, дуу бичлэг, зурган мэдээллийг боловсруулж шуурхай хүргэнэ.

5.2.12. төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дуудлага хүлээн авагч нь Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчтай хамтран тухайн газар хөдлөлт болсон газар орон, нөхцөл байдлыг тодруулан иргэдээс асуумж авч ШУЗМТ-д дамжуулах;

5.2.13. төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага нь тухайн газарт болсон газар хөдлөлтийн мэдээллийг орон нутгийн дуут дохиоллын цамхаг, радио, телевизийн нэвтрүүлэг, аж ахуйн нэгж, байгууллагын чанга яригч, дуут дохиоллын бүх төрлийн хэрэгслээр иргэдэд шуурхай хүргэх, заавар, зөвлөмж өгөх;

5.2.14. Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс нь гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийн дуут дохиоллын цамхгуудын тасралтгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хяналт тавина.

### 5.3. Цахим хөгжил, харилцаа холбооны яам:

5.3.1. үүрэн холбооны оператор компаниудтай мэдээ, мэдээлэл дамжуулах үйл ажиллагааны зохицуулалтын гэрээ байгуулна.

5.3.2. газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг “Үндсэн систем”-ээс дараах системүүд рүү дамжуулна. Үүнд:

5.3.2.1. үүрэн холбооны оператор компанийн “Мессеж дамжуулах систем”-рүү автоматаар 160 тэмдэгт бүхий мессежийг;

5.3.2.2. “Дэмжих систем”-ийн мэдэгдэл хүргэх систем рүү автоматаар мэдэгдлийг;

5.3.3. үндсэн системийн үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, хяналт тавих;

5.3.4. үндсэн систем болон дэмжих системийн хөгжүүлэлтийг хийх;

5.3.5. үндсэн систем болон дэмжих системийн хэвийн аюулгүй ажиллагааг хангах;

5.3.6. газар хөдлөлт болсон бүс нутгийн иргэдэд газар хөдлөлтийн мэдээллийг нэн тэргүүнд дамжуулах;

5.3.7. олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын зарлан мэдээлэл дамжуулах дундын системийн хөгжүүлэлтийг хийх;

5.3.8. олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгч байгууллагуудыг үүрэг чиглэл өгөх, хэрэгжилтийг хангуулна.

### 5.4. Үүрэн холбооны оператор:

5.4.1. иргэдийн гар утсанд газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийн масс мессежийг шуурхай дамжуулах;

5.4.2. үүрэн холбооны сүлжээ болон системийн найдвартай, хэвийн ажиллагааг хангах;

5.4.3. үндсэн системээс дамжуулсан мэдээллийг шууд дамжуулах;

5.4.4. газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг дараалал харгалзахгүй, үнэ төлбөргүй дамжуулах;

5.4.5. газар хөдлөлт болсон бүс нутгийн бааз станцад бүртгэгдсэн иргэдийн үүрэн холбооны дугаарт газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг нэн тэргүүнд дамжуулах;

5.4.6. газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг масс мессежээр дамжуулсан тайланг тухай бүр ШУЗМТ-д цахим шуудангаар ирүүлнэ.

### 5.5. Радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч нь:

5.5.1. Газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг тухай бүр шуурхай дамжуулахад шаардлагатай сүлжээ, түүний тоног төхөөрөмж, техникийн болон цахилгааны найдвартай ажиллагааг хангана.

#### Зургаа. Хориглох зүйл

6.1. Газар хөдлөлтийн мэдээ дамжуулах системийн техник хэрэгсэл, программ хангамжийг зориулалтын бусаар ашиглах, үйл ажиллагааг нь алдагдуулах, эвдэх, гэмтээх;

6.2. Системийн ашиглах хүрээг нь хязгаарласан өгөгдөл, мэдээ, мэдээлэлд хандах, өөрчлөх, хуулбарлах;

6.3. Сервер компьютер, техник, программ хангамжид хариуцсан албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр нэвтрүүлэх, ажиллуулах, засвар үйлчилгээ хийлгэх, өөр зорилгоор ашиглах.

#### Долоо. Бусад зүйл

7.1. Энэхүү журмын 5, 6 дугаар бүлэгт заасан үйл ажиллагаанд холбогдох байгууллагын дарга нар хяналт тавьж ажиллана.

7.2. Газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг дамжуулаагүй эсвэл алдаатай дамжуулсан тохиолдолд буруутай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэнэ.

7.3. Энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасан газар хөдлөлтийн мэдээлэл дамжуулах албан тушаалтнуудын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд Онцгой байдлын ерөнхий газрын дарга буюу Улсын онцгой комиссын орлогч даргын шийдвэрээр өөрчилж болно.

7.4 Энэхүү журмаар зохицуулагдаагүй бусад арга хэмжээг Одон орон геофизикийн хүрээлэнгийн захирал болон Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 онд хамтарсан тушаалаар батлагдсан "Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх систем хоорондын харилцан ажиллагааг зохицуулах журам", Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны 03 дугаар сарын 13-ны А/68 дугаар тушаалаар батлагдсан "Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх заавар"-ыг тус тус дагаж мөрдөнө.

## ООГХ-ИЙН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН УТГА, ДАМЖУУЛАХ ХҮСНЭГТ

Д/д	Дамжуулах байгууллага	Байршил	Төрөл	Газар хөдлөлтийн хүч /магнитуд/	Дамжуулах хэрэгсэл	Дамжуулах мэдээний утга	Дамжуулах хугацаа /минут/
1	ООГХ	Монгол орны нутаг дэвсгэр болон хил орчмын бүс нутагт	Анхдагч мэдээлэл	4.5-аас дээш	Цахим шуудан	Газар хөдлөлт болсон хугацаа (Улаанбаатарын цагаар): 2022/10/28 11:07:37 Газар зүйн байршил (Өргөрөг, Уртраг): 41.85 110.36 Газар хөдлөлтийн хүч (магнитуд): 5.5 Болсон газар: Хятад улсад  Шуурхай мэдээллийг бэлтгэсэн ШУА-ийн Одон орон, геофизикийн хүрээлэн	2
2			Хянасан мэдээ	3.5-аас дээш	Газар хөдлөлтийн мэдээлэл дамжуулах систем	Дуу бичлэг: Анхаараарай, анхаараарай, Дундговь аймгийн Өлзийт сумаас зүүн хойд зүгт 43 км-ийн зайд 4.8 магнитудын хүчтэй газар хөдлөлт боллоо.	10
					Цахим шуудан	Газар хөдлөлт болсон хугацаа (Улаанбаатарын цагаар): 2022/10/28 11:08:36 Газар зүйн байршил (Өргөрөг, Уртраг): 45.22 106.72 Газар хөдлөлтийн хүч (магнитуд): 4.9 Болсон газар: Дундговь аймгийн Өлзийт сумаас Зүүн хойд зүгт 43 км зайд  Шуурхай мэдээллийг бэлтгэсэн ШУА-ийн Одон орон, геофизикийн хүрээлэн Hyanasan medeelel: 2022-10-28-ni 11:08 tsagt Dundgovi aimgiin Ulziit sumaas zuun hoid zugt 43 km-t M4.9 gazar hudlult bolloo.	
3			Дэлгэрэнгүй мэдээлэл		Цахим хуудас	Тухайн газар хөдлөлтийн газар зүйн байршил, газар хөдлөлт болсон бүсийн ерөнхий мэдээлэл, чичирхийллийг онолын хувьд тооцоолсон зураг зэрэг мэдээлэл	120



## ИРГЭД, ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН МЭДЭЭЛЛИЙГ ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ ХҮСНЭГТ

д/д	Мэдээлэх алба хаагч/ систем	Мэдээлэл дамжуулах систем	Мэдээлэл хүргэх хэрэгсэл	Мэдээлэх хэлбэр	Газар хөдлөлтийн хүч			Мэдээлэх хугацаа /минут/	Мэдээлэл хүлээн авах субъект
					6.1 магнитуд ба түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт	5.6-6.0 магнитудын хүчтэй газар хөдлөлт	5.0-5.5 магнитудын хүчтэй газар хөдлөлт		
ООГХ-ээс газар хөдлөлтийн мэдээллийг хүлээн авснаас хойш зарлан мэдээллийг /бүх нийтийн болон хэсэгчилсэн байдлаар/ хүснэгтэд заасан хугацаанд багтаан мэдээлнэ.									
<b>1. ШУЗМТ</b>									
Улаанбаатар хот орчмын бүс нутгийг тойрсон газар хөдлөлтийн голомтод (Булган аймгийн Могод, Дундговь аймгийн Дэрэн, Сэлэнгэ аймгийн Бүрэн бүтээл) хүчтэй газар хөдлөлт болсон тохиолдолд амжиж анхааруулах системээр 1,2,3-р түвшний мэдээлэл ирнэ.									
<ul style="list-style-type: none"> <li>- 3-р түвшний үед зарлан мэдээлэх системийн дуут дохиоллын цамхаг телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгээр "Автоматаар" зарлан мэдээлнэ.</li> <li>- 2-р түвшний үед техникийн бэлэн байдал хариуцсан мэргэжилтэн зарлан мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулна.</li> <li>- 1-р түвшний үед зарлан мэдээлэл дамжуулахгүй.</li> </ul>									
Улаанбаатар хот орчмын бүсэд газар хөдлөлт болсон тохиолдолд									
1	Техникийн бэлэн байдал хариуцсан мэргэжилтэн	Зарлан мэдээлэх систем	Дуут дохиоллын цамхгийн чанга яригч	Дохио, дуу бичлэг, шууд яриа	Түгшүүрийн дохио - 1 удаа (30 секунд) Анхаараарай, Анхаараарай, Анхаараарай. Хүчтэй газар хөдлөлт боллоо. Аюулгүй байдлаа хангаарай. ОБЕГ (30 секунд) <i>Давталт – 3 удаа</i>	Сэрэмжлүүлэх дохио - 1 удаа (30 секунд) Иргэдийн анхааралд, Газар хөдлөлт боллоо. <i>Давталт – 3 удаа</i>	Иргэдийн анхааралд, Газар хөдлөлт боллоо. (30 секунд) <i>Давталт – 2 удаа</i>	2	Иргэд, олон нийтэд
Монгол орны нутаг дэвсгэр болон хил орчмын бүс нутагт газар хөдлөлт болсон тохиолдолд									
2			Дуут дохиоллын цамхгийн лед дэлгэцээр	Бичвэр мэдээлэл	Иргэдийн анхааралд, 2021.05.05-ны өдрийн 16:46 цагт Хөвсгөл аймгийн Ханх сумаас баруун урд зүгт 32 км зайд 6.6 магнитудын хүчтэй газар хөдлөлт боллоо. ОБЕГ	Иргэдийн анхааралд, 2021.05.05-ны өдрийн 16:46 цагт Хөвсгөл аймгийн Ханх сумаас баруун урд зүгт 32 км зайд 5.6 магнитудын хүчтэй газар хөдлөлт боллоо. ОБЕГ	Иргэдийн анхааралд, Газар хөдлөлт боллоо. 2021.05.05-ны өдрийн 16:46 цагт Хөвсгөл аймгийн Ханх сумаас баруун урд зүгт 32 км зайд 5.0 магнитудын хүчтэй газар хөдлөлт боллоо. ОБЕГ	0-5	Иргэд, олон нийтэд

						5.6 магнитудын хүчтэй газар хөдлөлт боллоо. ОБЕГ			
3			Телевиз	Бичвэр мэдээлэл, дуу бичлэг, шууд яриа, зурган мэдээлэл	Иргэдийн анхааралд, 2021.05.05-ны өдрийн 16:46 цагт Хөвсгөл аймгийн Ханх сумаас баруун урд зүгт 32 км зайд 6.6 магнитудын хүчтэй газар хөдлөлт боллоо. ОБЕГ	Иргэдийн анхааралд, 2021.05.05-ны өдрийн 16:46 цагт Хөвсгөл аймгийн Ханх сумаас баруун урд зүгт 32 км зайд 5.6 магнитудын хүчтэй газар хөдлөлт боллоо. ОБЕГ Иргэдийн анхааралд, 2021.05.05-ны өдрийн 16:46 цагт ОХУ-ын Тувад 5.6 магнитудын хүчтэй газар хөдлөлт боллоо. ОБЕГ	Иргэдийн анхааралд, 2021.05.05-ны өдрийн 16:46 цагт Хөвсгөл аймгийн Ханх сумаас баруун урд зүгт 32 км зайд 5.0 магнитудын хүчтэй газар хөдлөлт боллоо. ОБЕГ	0-4	Иргэд, олон нийтэд
4	Техникийн бэлэн байдал хариуцсан мэргэжилтэн		Радио	Дуу бичлэг, шууд яриа	Анхаараарай, Анхаараарай, Анхаараарай. Хүчтэй газар хөдлөлт боллоо. Аюулгүй байдлаа хангаарай. ОБЕГ Иргэдийн анхааралд, 2021.05.05-ны өдрийн 16:46 цагт Хөвсгөл аймгийн Ханх сумаас баруун урд зүгт 32 км зайд 6.6 магнитудын хүчтэй газар хөдлөлт боллоо. ОБЕГ <i>Давталт – 3 удаа</i>	Иргэдийн анхааралд, Газар хөдлөлт боллоо. Иргэдийн анхааралд, 2021.05.05-ны өдрийн 16:46 цагт Хөвсгөл аймгийн Ханх сумаас баруун урд зүгт 32 км зайд 5.6 магнитудын хүчтэй газар хөдлөлт боллоо. ОБЕГ <i>Давталт – 3 удаа</i>	Иргэдийн анхааралд, 2021.05.05-ны өдрийн 16:46 цагт Хөвсгөл аймгийн Ханх сумаас баруун урд зүгт 32 км зайд 5.0 магнитудын хүчтэй газар хөдлөлт боллоо. ОБЕГ <i>Давталт – 3 удаа</i>	0-8	
5	Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч	Цахилгаан холбоо	Цахилгаан холбоо	Шууд яриа	Газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг тухай бүр дамжуулах			0-5	ОБЕГ-ын удирдлагууд ҮАБЗ, гишүүд
6	Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор							1	ТОНОББ

7	ТОНОББ-ын дуудлага хүлээн авагч				Газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг тухай бүр дамжуулах	2	ТОНОББ-ын газар, хэлтсийн удирдлага
					Газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг тухай бүр дамжуулах, асуумж авах	3-10	сум, орон нутгийн удирдлага, иргэд
8	Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор	Үүрэн холбоо	Багц мессеж	Бичвэр мэдээлэл	<b>Anhdagch medeelel:</b> 2022-10-28-ni 11:08:36 tsagt Dundgovi aimgiin Ulziit sumaas zuun hoid zugt 43 km-t M4.9 gazar hudluit bolloo. OBEG	0-4	Хавсралт 3-т заагдсан эрх бүхий албан тушаалтан
					<b>Hyanasan medeelel:</b> 2022-10-28-ni 11:08 tsagt Dundgovi aimgiin Ulziit sumaas zuun hoid zugt 43 km-t M4.9 gazar hudluit bolloo. OBEG	0-4	
9	Автомат систем	Тусгай систем	Үндсэн систем	Бичвэр мэдээлэл	2022-10-28-ni udriin 11:08:36 tsagt Dundgovi aimgiin Ulziit sumaas zuun hoid zugt 43 km-t 4.9 magnitudiin huchtei gazar hudluit bolloo. OBEG	0-3	Иргэд, олон нийт
10					Иргэдийн анхааралд, 2021.05.05-ны өдрийн 16:46 цагт Хөвсгөл аймгийн Ханх сумаас баруун урд зүгт 32 км зайд 5.6 магнитудын хүчтэй газар хөдлөлт боллоо. ОБЕГ	0-3	
<b>2. ОБЕГ, УСГ-ЫН ОНХТ</b>							
11	ОНХТ-ийн мэргэжилтэн	Цахим сүлжээ	Цахим хуудас	Бичвэр мэдээлэл	ОБЕГ-ын вэб сайтад газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг тухай бүр нийтлэх	~0-10	Иргэд, олон нийт
12					Нийгмийн сүлжээнд	Олон нийтийн сүлжээнд газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг тухай бүр нийтлэх	
<b>3. МЭДЭГДЭЛ ХҮРГЭХ СИСТЕМ</b>							
13	Автомат систем	Үндсэн систем	И-Монгол гар утасны аппликей шн	Мэдэгдэл	Иргэдийн анхааралд, 2021.05.05-ны өдрийн 16:46 цагт Хөвсгөл аймгийн Ханх сумаас баруун урд зүгт 32 км зайд 5.6 магнитудын хүчтэй газар хөдлөлт боллоо. ОБЕГ	20	Иргэд, олон нийт
			Үндэсний цахим шуудан		Иргэдийн анхааралд, 2021.05.05-ны өдрийн 16:46 цагт Хөвсгөл аймгийн Ханх сумаас баруун урд зүгт 32 км зайд 5.6 магнитудын хүчтэй газар хөдлөлт боллоо. ОБЕГ	30	
<b>4. ҮҮРЭН ХОЛБООНЫ ОПЕРАТОР КОМПАНИ</b>							
14	ҮХОК-ын мэргэжилтэн/автомат систем	Үндсэн систем	Дамжуулах систем	Масс мессеж	2021.05.05-ni udriin 16:46 tsagt Khuvs gul aimgiin Hanh sumaas urd zugt 40km-t mt=6.7 huchtei gazar hudluit bolloo. OBEG	180-240	Иргэд, олон нийт

**ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН МЭДЭЭЛЛИЙГ ГАР УТАСНЫ МЕССЕЖЭЭР  
ХҮЛЭЭН АВАХ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ЖАГСААЛТ**

д/д	Албан тушаал
<b>ШУЗМТ</b>	
1	Монгол Улсын Ерөнхийлөгч
2	Монгол Улсын Их хурлын дарга
3	Монгол Улсын Ерөнхий сайд
4	Монгол Улсын Шадар сайд
5	Барилга хот байгуулалтын сайд
6	Батлан хамгаалахын сайд
7	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд
8	Эрчим хүчний сайд
9	Байгаль орчин аялал жуулчлалын дэд сайд
10	Зам тээврийн хөгжлийн дэд сайд
11	Эрүүл мэндийн дэд сайд
12	Эрчим хүчний дэд сайд
13	Барилга хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн дарга
14	Гадаад харилцааны яамны төрийн нарийн бичгийн дарга
15	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн дарга
16	Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн дарга
17	Ерөнхийлөгчийн туслах
18	Улсын Их хурлын даргын туслах
19	Ерөнхий сайдын ахлах зөвлөх бөгөөд ажлын албаны дарга
20	Ерөнхий сайдын туслах
21	Шадар сайдын ажлын албаны дарга
22	Шадар сайдын зөвлөх
23	Шадар сайдын туслах
24	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ахлах шинжээч
25	Онцгой байдлын ерөнхий газрын дарга
26	Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга
27	Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга 1
28	Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга 2
29	Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга
30	ОБЕГ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга
31	ОБЕГ-ын Урьдчилан сэргийлэх газрын дарга
32	ОБЕГ-ын Ажиллагааны удирдлагын газрын Мэргэжлийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга
33	ОБЕГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга
34	ОБЕГ-ын Ажиллагааны удирдлагын газрын дэд бүтэц, газар хөдлөлтийн тасгийн дарга
35	ОБЕГ-ын даргын туслах
36	ОБЕГ-ын Ажиллагааны удирдлагын газрын дэд бүтэц, газар хөдлөлтийн тасгийн мэргэжилтэн
37	ОБЕГ-ын Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвийн дарга
38	ОБЕГ-ын Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвийн орлогч дарга
39	ЗГХЭГ-ын Салбарын удирдлага зохицуулалтын газрын референт
40	ЗГ-ын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газар

41	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын дарга
42	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга
43	Стандарт, хэмжил зүйн газрын дарга
44	Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга
45	Үндэсний геологийн албаны дарга
46	МҮОНРТ-ийн ерөнхий захирал
47	МУЗН-ийн ерөнхий нарийн бичгийн дарга
48	Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга
<b>НОБГ-ын Дэд төв</b>	
1	Нийслэлийн Иргэдийн Тэргүүлэгчдийн Хурлын дарга
2	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч
3	Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч
4	Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч
5	Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга
6	Нийслэлийн шуурхай удирдлага, зохицуулалтын төв /05/
<b>Аймгийн Онцгой байдлын газар</b>	
1	Аймгийн Онцгой комиссын дарга, гишүүд
2	Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч

Жич: Дээрх дугааруудыг сар бүрийн 15-ны өдөр Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвийн Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор тодотгож, тодотгосон тухай төвийн даргад танилцуулж, баталгаажуулж ажиллана.

---oOo---

# ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧ

